

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН"-д ОЛГОСОН ЗЭЭЛ, ЭРГЭН ТӨЛӨЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ӨМА-2026/21-15-ШТА-ГА

**"ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН"-ИЙ ХҮРЭЭНД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ҮР ДҮНГ
ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ТОДОРХОЙГҮЙ БАЙНА**

Дарга, Тэргүүлэх аудитор Ю.Энхтуяа

Утас: 70533539 Цахим хаяг Enkhtuyayu@audit.gov.mn

Аудитын менежер Ц.Өсөхбаяр

Утас: 70533552 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитор А.Ганзуузай

Утас: 70533552 Цахим хаяг: Ganzuuzai@audit.gov.mn

Аудитор М.Номиндарь

Утас: 70533552 Цахим хаяг: Nomindarim@audit.gov.mn

Даланзадгад хот 2026 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар
авна уу: Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	2
ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	2
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	3
БҮЛЭГ 1. “ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН”-ИЙ ҮР ДҮНГ ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН ТОДОРХОЙГҮЙ БАЙНА.	6
А.1 Хоршоодын зорилго, зорилт хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаа нь Өмнөговь аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн агуулгатай нийцэж байна	6
БҮЛЭГ 2. ЗЭЭЛИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ АШИГЛАЖ ҮР ӨГӨӨЖИЙГ МАЛЧИД ХҮРТЭЖ БАЙГАА БОЛОВЧ ХОРШИЖ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛААГҮЙ БАЙНА.....	8
Б.1 Зээлийн эргэн төлөлт хэвийн байна	8
Б.2 Хөнгөлөлттэй зээл авсан малчид холбогдох шалгуурыг хангасан байна	9
ДҮГНЭЛТ	12
ЗӨВЛӨМЖ	13
ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ТАЙЛБАР.....	14
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛАХ ТУШААЛ.....	15

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар

ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	"Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд олгосон зээлийн мэдээлэл	5
Хүснэгт 2	Зээл авсан малчдын зээлийн зориулалт, зарцуулсан мөнгөн дүн	6
Хүснэгт 3	Шинээр байгуулагдсан хоршоодын мэдээлэл /сумдаар/	8
Хүснэгт 4	"Шинэ хоршоо хөдөлгөөн"-д олгосон зээлийн мэдээлэл /сумдаар/	10
Хүснэгт 5	Үндсэн зээлийн эргэн төлөлтийн мэдээлэл	10
График 1	Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хоршоодын болон шинээр байгуулагдсан хоршоодын тоо	8

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар тогтоолоор баталсан Төрийн аудитын байгууллагын 2026 оны гүйцэтгэх аудитын сэдэв, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/179 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө"-ний дагуу "Шинэ хоршоо хөдөлгөөн"-д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилго

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолын хүрээнд малчинд олгосон зээл, эргэн төлөлт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, аудитын дүнг УИХ-ын холбогдох Байнгын хороо, шалгагдагч байгууллага, албан тушаалтанд танилцуулж олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

1. Төрөөс "Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх" чиглэлээр тодорхойлсон хөтөлбөр үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх;
2. Хоршоог хуульд заасан шаардлагын дагуу байгуулж, олгосон зээлийг зориулалтын дагуу ашиглаж, үр дүнг тооцож байгаа эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Өмнөговь аймаг дахь Хаан банкны салбар, Өмнөговь аймаг дахь Төрийн банкны салбар болон "Шинэ хоршоо хөдөлгөөний" хүрээнд 2024-2025 онд хоршооны малчдад олгосон зээл, түүний зориулалт, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны болон холбогдох байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан зэргийг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 3000, 4000, Монгол Улсын төрийн аудитын багц стандарт MNS 6817-2020 "Төрийн аудитын стандарт", "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ыг ашиглан холбогдох байгууллагаас ирүүлсэн судалгаа, мэдээлэл, эрх бүхий байгууллагын хяналтын тайлан, цахим болон цаасан суурьтай нотлох баримтад үндэслэн асуулга лавлагаа, судалгаа мэдээллийг нягтлан шалгаж, тодруулга авч нэгтгэх, дүн шинжилгээ хийж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын шалгуур үзүүлэлт:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Хууль:

- Төрийн аудитын тухай хууль;
- Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль
- Хоршооны тухай хууль
- Банкны тухай хууль
- Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль

Холбогдох журам:

"Шинэ хоршоо хөдөлгөөн"-д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн

- *Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 166 дугаар "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай тогтоол*
- *Сангийн сайдын 2022 оны А/155 дугаар тушаалаар баталсан "Хоршооны нягтлан бодох бүртгэл"-ийн журам;*
- *"Хоршооны гишүүн малчны зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээ" 2024 оны 240509/84, 240508/03-372, 1824/173 дугаар гэрээ*
- *ЗГ-ын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах" журам*
- *Холбогдох бусад захиргааны хэм хэмжээний акт*

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ю.Энхтуяа хянан удирдаж, аудитын менежер Ц.Өсөхбаяр, Т.Хонгорзул нар үе шатны хяналтыг хэрэгжүүлж, аудитор А.Ганзуузай, М.Номиндарь нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Ерөнхий мэдээлэл:

Засгийн газрын 2024 оны "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолоор "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан мал аж ахуйн салбарт үүсэж болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын хоршоог дэмжих замаар тогтвортой хөгжүүлэх зорилгоор "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэхээр 5 (тав) их наядын "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" 2 чиглэлийн хүрээнд 13 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг баталсан байна.

"Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд 2024, 2025 онуудад 96 хоршооны гишүүн 307 малчинд нийт 12,392.5 сая төгрөгийн зээлийг тус аймаг дахь Хаан банк болон Төрийн банкнуудаар дамжуулан олгосон байна. Үүнээс:

Төрийн банк нь 73 хоршооны 239 малчинд 9,972.5 сая төгрөгийг зээл олгосон бол Хаан банк нь 23 хоршооны 68 малчинд 2,420.0 сая төгрөгийн зээлийг тус тус олгосон байна.

Хүснэгт 1: "Шинэ хоршоо хөдөлгөөний" хүрээнд олгосон зээлийн мэдээлэл (сая.төгрөг)

№	Сумын нэр	Хоршооны тоо	Малчны тоо	"Хаан банк" олгосон зээлийн дүн	"Төрийн банк" олгосон зээлийн дүн	Зээлийн нийт дүн
1	Баяндалай	14	58	146.0	2,055.2	2,201.2
2	Баян-Овоо	2	13	500.0	-	500.0
3	Булган	2	3	37.0	100.0	137.0
4	Гурвантэс	8	31	383.5	647.5	1,031.0
5	Даланзадгад	11	28	40.0	1,240.8	1,280.8
6	Мандал-Овоо	10	32	80.0	1,269.0	1,349.0
7	Номгон	12	41	430.0	1,333.1	1,763.1
8	Ноён	15	48	292.0	1,650.2	1,942.2
9	Сэврэй	4	15	462.5	-	462.5
10	Ханбогд	9	14	-	676.8	676.8
11	Ханхонгор	3	6	49.0	244.9	293.9
12	Хүрмэн	2	10	-	375.0	375.0
13	Цогт-Овоо	1	3	-	130.0	130.0
14	Цогтцэций	3	5	-	250.0	250.0
Нийт		96	307	2,420.0	9,972.5	12,392.5

БҮЛЭГ 1. "ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН"-ИЙ ҮР ДҮНГ ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН ТОДОРХОЙГҮЙ БАЙНА.

А.1 Хоршоодын зорилго, зорилт хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаа нь Өмнөговь аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн агуулгатай нийцэж байна

1.1. Өмнөговь аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн гуравдугаар бүлгийн эдийн засгийн бодлогын хүрээнд:

- Малчдын орлогыг нэмэгдүүлэх, малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, улирлын нөлөөнөөс бага хамааралтай, зорилготой "Чинээлэг малчин" хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Малын тэжээлийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор бэлчээр хашиж хамгаалах, тэжээлийн ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх;
- Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, уст цэгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах зэрэг арга хэмжээг төлөвлөсөн байна.

1.2. Аймгийн хэмжээнд "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд зээл авсан малчид нийт 12 чиглэлээр 367 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

1.3. Үүнээс хамгийн их буюу 56,6 хувь нь "үржлийн мал худалдан бойжуулах борлуулах" чиглэлээр нийт 7,767.8 сая төгрөгийг, хамгийн бага буюу 0,2 хувь нь "дотор мах боловсруулах үйлдвэр, цех байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх" чиглэлээр 9.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 2: Зээлийн зориулалт, зарцуулсан мөнгөн дүн

(сая.төгрөг)

№	Зээлийн зориулалт, чиглэл	Арга хэмжээний тоо	Зарцуулсан мөнгөн дүн
1	Үржлийн мал худалдан бойжуулах борлуулах	210	7,785.8
2	Мал бордох аж ахуй байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	48	1,156.9
3	Мах сүү цагаан идээ бэлтгэх боловсруулах үйлдвэрлэл цех байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	23	857.6
4	Мал төхөөрөх цех үйлдвэр байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	21	606.5
5	ХААн гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийн зориулалттай барилга байгууламж барих өргөтгөх засварлах тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл автомашин тоног төхөөрөмж худалдан авах	18	590.2
6	Бэлчээрт худаг уст цэг гаргах усан хангамж байгуулах	17	453.1
7	Бүх төрлийн тэжээлийн ургамал тариалах тэжээлийн үйлдвэрлэл цех байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	12	386.3
8	Мал аж ахуйн үйлдвэрлэлд зориулагдсан малчдын хөдөлмөрийг хөнгөвчилсөн техник тоног төхөөрөмжийн дундын үйлчилгээ үзүүлэх технологи нэвтрүүлэх	6	154.0
9	Ноос ноолуур арьс шир бэлтгэх анхан шатны тордолт хийх цэг цех байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	5	150.5
10	Мал аж ахуйн үйлдвэрлэлд зориулагдсан малчдын хөдөлмөрийг хөнгөвчилсөн техник тоног төхөөрөмжийн дундын үйлчилгээ үзүүлэх технологи нэвтрүүлэх	4	142.0
11	Гахай шувуу зөгий цаа буга зэрэг ашиг шимийг нь тогтмол хүртдэг тэжээвэр амьтны аж ахуй байгуулах өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	2	100.0
12	Дотор мах боловсруулах үйлдвэр, цех байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	1	9.6
Нийт		367	12,392.5

1.4. Засгийн газрын 2024 оны "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Шинэ хоршоо-чинээлэг малчин" төлөвлөгөөнд тусгасан нийт 13 арга хэмжээнээс 6 арга хэмжээг аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран хэрэгжүүлэхээр байна.

1.5. Тус арга хэмжээний хүрээнд аймгийн ЗДТГ нь дараах арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна. Үүнд:

➤ "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийг эхлүүлэх төв, орон нутгийн нэгдсэн арга хэмжээнд Өмнөговь аймгаас нийт 138 малчид болон холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулсан;

➤ "Шинэ хоршоо хөдөлгөөн" говийн бүсийн нээлтийн арга хэмжээг 2024 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Даланзадгад суманд зохион байгуулж Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Өмнөговь аймгийн 570 малчин, холбогдох албан байгууллагын төлөөлөл 130 нийт 700 иргэнийг хамруулсан;

➤ Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан 17 төрийн албан хаагчийг орон нутгийн сургагч багшаар бэлтгэсэн;

➤ "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд Засгийн газраас томилогдсон 30 зөвлөн туслах мэргэжилтэн, 15 сумын хүнс хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн, багийн Засаг дарга нар хамтран нийт 4821 малчин өрхөд мэдээлэл хүргэж зөвлөн туслаж ажилласан байна.

1.6. Мөн Монгол Улсын Шадар сайдын 2024 оны 11 сарын 25-ны өдрийн 103 дугаар тушаалын дагуу аймгийн Засаг даргын 2024 оны А/2153 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэг "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 68 хоршооны 216 гишүүн малчдын авсан зээлээрээ хэрэгжүүлсэн үйл ажиллагаатай танилцаж асуумж, судалгааг авч нэгтгэн Шадар сайдад хүргүүлсэн байна.

1.7. Хоршооны гишүүн малчны зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээний долоодугаар бүлэгт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам, Монгол банк болон арилжааны банкуудын эрх, үүргийг тодорхой тусгаж өгсөн байна.

1.8. Мөн дээрх гэрээнд банк нь холбогдох тайлан мэдээг зөвхөн Монгол банк болон Зээлийн батлан даалтын санд гаргаж өгөхөөр тусгасан бөгөөд холбогдох Төрийн байгууллагад мэдээ, тайлан өгөх зохицуулалтгүй байна.

1.9. Орон нутгийн холбогдох төрийн байгууллагууд нь тус хөдөлгөөний хүрээнд олгосон зээл олголт, зээлдэгчдийн хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх нэгдсэн мэдээлэлгүй байна.

1.10. "Шинэ хоршоо-чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөө, хоршооны гишүүн малчны зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээнд аймаг, сумын Засаг дарга болон төрийн байгууллагуудын цаашдын оролцоо чиг үүргийг тодорхой тусгаагүй ба зээлийн зарцуулалт, үр дүнд хяналт тавиагүй, хоршооны үйл ажиллагааг өргөжүүлэх, хөгжүүлэх чиглэлээр ямар нэг үйл ажиллагаа зохион байгуулаагүй байна.


БҮЛЭГ 2. ЗЭЭЛИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ АШИГЛАЖ ҮР ӨГӨӨЖИЙГ МАЛЧИД ХҮРТЭЖ БАЙГАА БОЛОВЧ ХОРШИЖ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛААГҮЙ БАЙНА

Б.1 Зээлийн эргэн төлөлт хэвийн байна

2.1. Аймгийн хэмжээнд нийт 283 хоршоо (2025 оны жилийн эцсийн байдлаар) бүртгэлтэй байгаагаас 96 хоршооны малчид "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хөнгөлөлттэй зээлд хамрагдсан байна.

2.2. Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 96 хоршооноос 83 хоршоо нь 2024-2025 онуудад шинээр үүсгэн байгуулагдсан байна.

График 1: Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хоршоодын болон шинээр байгуулагдсан хоршоодын тоо



2.3. Хоршоод нь дүрэмдээ хоршооны зорилго, эрх, үүрэг, хариуцлагыг тусгаж бүх гишүүдийн хурлаар баталсан байна.

Хүснэгт 3: 2024-2025 онд шинээр байгуулагдсан хоршоодын мэдээлэл /сумдаар/

№	Сумын нэр	Хоршооны хэлбэр	Хоршооны тоо	Гишүүдийн тоо
1	Баяндалай	Анхан шатны	12	126
2	Баян-Овоо	Анхан шатны	1	12
3	Булган	Анхан шатны	2	18
4	Гурвантэс	Анхан шатны	8	87
5	Даланзадгад	Анхан шатны	9	86
6	Мандал-Овоо	Анхан шатны	9	85
7	Номгон	Анхан шатны	10	94
8	Ноён	Анхан шатны	13	124
9	Сэврэй	Анхан шатны	4	43
10	Ханбогд	Анхан шатны	8	74
11	Ханхонгор	Анхан шатны	2	21
12	Хүрмэн	Анхан шатны	2	31
13	Цогт-Овоо	Анхан шатны	1	12
14	Цогтцэций	Анхан шатны	2	18
Нийт			83	831

2.4. Хоршооны дүрэмд гишүүдийн заавал оруулах хөрөнгийн хувь хэмжээг 5000.00-300,000.00 төгрөгийн хооронд байхаар тусгаж баталсан байна.

2.5. Хоршооны дүрэмд "Хоршооны хөгжил, хоршооны гишүүний нийгэм, эдийн засгийн байдлыг дээшлүүлэх, амьдралын чанар, амьдрах орчныг сайжруулах зорилгоор хоршоо

хөгжлийн сантай байж болно” гэж тусгасан хэдий ч зээлд хамрагдсан 96 хоршоо нь хөгжлийн сан байгуулаагүй, хөрөнгө төвлөрүүлээгүй байна.

2.6. Мөн дүрэмд “Хоршооны тухайн жилийн борлуулалтын нийт орлогын 20 хүртэл хувийг болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуваарилна” гэж тусгасан боловч шинээр байгуулагдсан хоршоод үйл ажиллагаагаа хоршиж эрхлээгүй, эрсдэлийн сантай болоогүй байна.

2.7. Харин 2010 онд үүсгэн байгуулагдсан 1 хоршоо болзошгүй эрсдэлээс хамгаалах санд 38.1 сая төгрөг байршуулсан байна.

2.8. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1¹-д зааснаар аж ахуйн нэгж, байгууллага хагас жилийн санхүүгийн тайланг 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн санхүүгийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор² харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлэх үүрэгтэй.

2.9. Гэвч хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хоршоодын 39 хоршоо буюу 41 хувь нь санхүүгийн тайлан гаргаж бүртгэл хөтөлсөн, 57 хоршоо буюу 59 хувь санхүүгийн тайлан гаргаагүй байна.

2.10. Сангийн сайдын 2022 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн А/155 дугаар тушаалаар “Хоршооны нягтлан бодох бүртгэлийн журам”, “Хоршооны санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ыг баталж журам, зааврыг хоршооны санхүүгийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга нарт үүрэг болгосон байна.

2.11. Хоршооны тухай хуулийн 43 дугаар зүйлд³ аймаг, сумын Засаг дарга хоршоог дэмжих, хоршооны үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хоршооны бараа, бүтээгдэхүүний борлуулалт болон хоршоод үйл ажиллагааны чиглэлээр хорших, харилцан уялдаатай хамтын ажиллагааг дэмжих ажлыг зохион байгуулах бүрэн эрхийг заасан байна.

2.12. Иймд шинээр байгуулагдсан хоршоодын үйл ажиллагааг тогтмолжуулах чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах, хууль, журмыг сурталчлах, холбогдох мэдээ тайлан, судалгааг гаргах, Сангийн сайдын баталсан журам, зааврыг хоршооны санхүүгийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад өглөө.

Б.2 Хөнгөлөлттэй зээл авсан малчид холбогдох шалгуурыг хангасан байна

2.13. Банкнууд “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 3.1⁴-д заасан шаардлага хангасан 307 малчинд “хоршооны гишүүн малчны зээл”-ийг олгосон байна.

¹ 9.1. Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангаа энэ хуулиар тогтоосон хугацаанд харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлэх үүрэгтэй.

² Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 Энэ хуулийн 4.1.1-д заасан стандартыг мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага нь эхний хагас жилийн санхүүгийн тайланг 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн санхүүгийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлнэ.

³ 43.2.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга хоршооны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 43.2.1.хоршоог дэмжих, хоршооны үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; 43.2.2.хоршооны бараа, бүтээгдэхүүний борлуулалт болон хоршоод үйл ажиллагааны чиглэлээр хорших, харилцан уялдаатай хамтын ажиллагааг дэмжих ажлыг зохион байгуулах; 43.2.3.хуульд заасан бусад бүрэн эрх.

⁴ 3.1 Зээлдэгч нь дараах бүх шаардлагыг хангасан байна.

3.1.1 Зээл хүсэгч нь хоршооны гишүүн малчин байх.

3.1.2 Үндсэн зээлдэгчийн нэр дээр мал тооллогод хамрагдсан байх.

3.1.3 Хоршооны үйл ажиллагаа эрхлэх хот аймагт оршин суудаг байх.

3.1.4 Хугацаа хэтэрсэн чанаргүй зээлийн өр төлбөрийн үлдэгдэлгүй байх.

3.1.5 Гишүүнчлэлтэй хоршоо нь бизнес төлөвлөгөөтэй байх бөгөөд зээлдэгч нь бизнес төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэх гэрээг хэрэгжүүлэгч талуудтай байгуулсан байх.

3.1.6 Суурин барилга, байгууламж барих, өргөтгөх зориулалтаар хүсэлт гаргасан зээл хүсэгч нь өөрийн эсхүл хоршоо, хоршооны бусад гишүүдийн нэр дээр өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй газартай байх.

Хүснэгт 4: "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ний хүрээнд олгосон зээлийн мэдээлэл /сумдаар/ (сая.төгрөг)

№	Сумын нэр	Хоршооны тоо	Малчны тоо	Олгосон зээлийн дүн
1	Баяндалай	14	58	2,201.2
2	Баян-Овоо	2	13	500.0
3	Булган	2	3	137.0
4	Гурвантэс	8	31	1,031.0
5	Даланзадгад	11	28	1,280.8
6	Мандал-Овоо	10	32	1,349.0
7	Номгон	12	41	1,763.1
8	Ноён	15	48	1,942.2
9	Сэврэй	4	15	462.5
10	Ханбогд	9	14	676.8
11	Ханхонгор	3	6	293.9
12	Хүрмэн	2	10	375.0
13	Цогт-Овоо	1	3	130.0
14	Цогтцэций	3	5	250.0
Нийт		96	307	12,392.5

2.14. Аймгийн Статистикийн хэлтсээс ирүүлсэн судалгаанаас үзэхэд хөнгөлөлттэй зээл авсан 307 иргэнээс 13 нь "Мал бүхий этгээд"⁵ байна.

2.15. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-ийн "Малчны тодорхойлолт"-оор "Мал бүхий этгээд" нь малчин гэж тодорхойлогдож байх учир арилжааны банкнаас шаардлага хангасан гэж үзсэн байна.

2.16. "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд олгосон нийт 12,392.5 сая төгрөгийн зээлээс 2026 оны эхний улирлын байдлаар 1,726.1 сая төгрөгийн үндсэн зээлийн төлөлт хийгдэж 10,666.4 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

2.17. Зээлийн хуваарийн дагуу төлбөл зохих дүнгээс 339.8 сая төгрөгийн илүү төлөлттэй байна.

Хүснэгт 5: Үндсэн зээлийн эргэн төлөлтийн мэдээлэл (сая төгрөг)

№	Банк	Олгосон зээлийн дүн	Эргэн төлөлтийн дүн	Зээлийн үлдэгдэл
1	Төрийн банк	9,972.5	1,572.4	8,404.6
2	Хаан банк	2,420.0	175.6	2,244.4
Нийт		12,392.5	1,726.1	10,666.4

2.18. Нийт зээл авсан 307 малчнаас 7 малчин 294.0 сая төгрөгийн зээлийг хугацаанаас нь өмнө бүрэн төлж барагдуулсан ба үлдсэн 300 зээлдэгчийн зээлийн эргэн төлөлт хэвийн байна.

2.19. Арилжааны банкны салбарууд "Хоршооны гишүүн малчны зээл"-ийн зарцуулалтад зээл олголтын дараах хяналтыг 1 удаа хийсэн байна.

3.1.7 Банкнаас зээлийн үйл ажиллагаатай холбоотой журам, зааврын хүрээнд тавигдах бусад холбогдох шаардлага.

⁵ Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "мал бүхий этгээд" гэж энэ хуулийн 3.1.2-т зааснаас бусад малыг өмчилж байгаа этгээдийг;

2.20. Тус хяналтаар дараах шалтгаан нөхцөлөөр 3 зээлдэгч нь зээлийн санхүүжилтийн зарим хэсгийг зориулалт бусаар зарцуулсан гэж үзэж 28.0 сая төгрөгийг энгийн хүүтэй зээл рүү шилжүүлсэн байна. Үүнд:

- Авбал зохих тооны мал аваагүй тул аваагүй малын тоонд хамаарах 8.0 сая төгрөг;
- Төлбөр тооцоог дансаар биш бэлнээр хийсэн 10.0 сая төгрөг;
- Зээлийг банкнаас шилжүүлсэн иргэний данснаас буцаж зээлдэгчийн дансанд орсон 10.0 сая төгрөг тус тус байна.

2.21. Өмнөговь аймаг дахь Монгол банкны салбараас нийт 95 хоршооны 298 зээлдэгчид олгосон зээл, эргэн төлөлтөд хяналт хэрэгжүүлсэн ба 2025 оны 12 дугаар сард зээл авсан 1 хоршооны зээлдэгчид тус хяналтад хамрагдаагүй байна.

2.22. Зээлийн батлан даалтын санд 138 зээлдэгчийн 5,627.5 сая төгрөгийн зээл хамрагдсан байна.

2.23. Зээлийн батлан даалтын сангаас 2024, 2025 онуудад Дундговь болон Өмнөговь аймгийн "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн төслийн хэрэгжилттэй танилцаж зээлийн эргэн төлөлт хэвийн, батлан даалттай зээлийг зориулалтын дагуу зарцуулсан гэж үзжээ.

2.24. Харин зээлийн батлан даалтын сангийн тайланд *"зээлийн зориулалтыг тогтоох боломжгүй зориулалт бус байж болзошгүй гэж үзсэн зээлдэгчийн мэдээллийг арилжааны банканд мэдэгдэн холбогдох арга хэмжээг авч ажилласан"* гэх боловч аль аймаг, сум, хоршооны зээлдэгч гэдэг нь тодорхойгүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий үр дүнг орон нутгийн түвшинд үнэлэх боломжгүй, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин тодорхойгүй байна.
- Хоршоодын зорилго, зорилт хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаа нь Өмнөговь аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн агуулгатай нийцэж байна.
- “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээнд аймгийн Засаг даргын чиг үүргийг тусгаагүй ба гэрээний хэрэгжилт, үр дүнд хяналт тавиагүй байна.
- Зээлийг зориулалтын дагуу ашиглаж үр өгөөжийг малчид хүртэж байгаа боловч хоршоо хөгжөөгүй буюу хоршиж үйл ажиллагаа явуулаагүй байна.
- Аймгийн Засаг дарга нь “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд шинээр байгуулагдсан хоршоодын хувьд Хоршооны тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хоршоодын 59 хувь нь санхүүгийн тайлан гаргаагүй байна.
- Зээлийн эргэн төлөлт хэвийн бөгөөд төлбөл зохих дүнгээс 339.8 сая төгрөгийн илүү төлөлттэй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД:

1. Шинээр байгуулагдсан хоршоодыг хөгжүүлэх, үйл ажиллагааг тогтмолжуулахад шаардлагатай сургалтыг сумдын Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагатай хамтран зохион байгуулж хоршоодын үйл ажиллагаанд 2026 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийх;

2. Сангийн сайдын баталсан журам, зааврыг хоршоодын санхүүгийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд гаргуулж хэвших.

"Шинэ хоршоо хөдөлгөөн"-д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ТАЙЛБАР



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Нутгийн удирдлагын ордон, 3-р баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, Монгол улс
Утас: 7053 0001, Факс: (+976) 7053 0002
Цахим шуудан: info@omnogovi.gov.mn
Цахим хуудас: www.omnogovi.gov.mn

2026.06.29 № 01/3184
танай _____-ны № _____-т

Г ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР Г

Улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар 2026 онд гүйцэтгэсэн "Шинэ хоршоо хөдөлгөөнд олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн"-д хийгдсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд тусгах санал байхгүй болно.



Өмнөговь аймгийн засаг даргын тамгын
газар
Захиргаа
Засаг даргын орлогч
Жаргал Занабазар
2026.06.30 11:00:29

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛАХ ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/23

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2025 оны "Эрх шилжүүлэх тухай" А/175 дугаар тушаалын гуравдугаар хавсралтын 3-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Шинэ хоршоо хөдөлгөөнд олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газарт болон аймгийн Засаг даргад хүргүүлэхийг Аудитор (А.Ганзуузай)-т даалгасугай.
3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг Аудитор (М.Номиндарь)-т үүрэг болгосугай.



Ю.ЭНХТУЯА

4626010040

Хаяг: Монгол улс, Өмнөговь аймаг, Даланзадгад сум
3 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон 3 давхар
Утас: +976 70533559, +976 70533552
И –мэйл: umnugovi@audit.gov.mn,
Вебсайт: www.audit.mn